


Багш. Гүйцэтгэх хугацаа: 90 минут

1. *Философид объектив гэдэг үг юу гэсэн утгатай байдаг вэ?*
 - a. Хүн, хүн төрөлхтөн өөртөө оногдуулсан ойлголт
 - b. Хүн, хүн төрөлхтний тодорхой үйлдэл
 - c. Хүн, хүн төрөлхтний бүхий л үйлдэл
 - d. Хүн, хүн төрөлхтнөөс хамаарахгүй оршдог зүйл
2. *Мэдлэгийн тухай асуудлыг авч үздэг философийн салбарын нэр аль нь вэ?*
 - a. Методологи
 - b. Эпистемологи
 - c. Онтологи
 - d. Аксиологи
3. *Орчин үеийн философийн арга зүйн үүднээс авч үзвэл аль нь зохистой вэ?*
 - a. Түгээмэл хууль, үнэмлэхүй үнэн байх боломжгүй
 - b. Түгээмэл хууль, үнэмлэхүй үнэн байх боломжтой
 - c. Философи бол мөн чанарыг судлах ёстой
 - d. Философи бол зөвхөн шинжлэх ухаан байх ёстой
4. *Цэгийн оронд тохирох зөв хариултыг сонгоно уу. "Экзистенци" гэдэг үг нь гэсэн утгатай юм.*
 - a. Объектив ертөнц
 - b. Далд, чинад ертөнц
 - c. Үнэлэмж
 - d. Хүний оршихуй
5. *"Хүн бол улс төрийн (полисын) амьтан мөн" гэж хэн томъёолсон бэ?*
 - a. Аристотель
 - b. Ф.Ницше
 - c. Э.Кассирер
 - d. К.Маркс
6. *Хувийн өмчийг устгаснаар л хүн хүнээ мөлжих ёсыг үүрд устгаж болно гэж аль нь үздэг вэ?*
 - a. Коммунизм
 - b. Либертарианизм
 - c. Консерватизм
 - d. Бүгд
7. *Бурхан тэнгэр байдгийг үгүйсгэдэг үзэл аль нь вэ?*
 - a. Атеизм
 - b. Монотеизм
 - c. Политеизм
 - d. Теизм
8. *Хүний мөн чанарыг нийгмийн харилцаатай холбон үздэг үзэл аль философид хамаарах вэ?*
 - a. Эртний философи
 - b. Марксист философи
 - c. Сонгодог бус философи
 - d. Постфилософиуд
9. *Философид байдаг гарцаагүй шинжүүдийг дурдахдаа хамааралгүй зүйл дурдсан нь аль вэ?*
 - a. Эргэлзэх сэтгэлгээ
 - b. Шүүмжлэлт сэтгэлгээ
 - c. Асуулт тавих, маргах
 - d. Ямагт үл итгэх сэтгэлгээ
10. *"Сайн үйл", "аз жаргал" гэсэн хоёр ойлголт уг үндсээрээ ижил гэж үзээд тэдгээрийг хослуулахын чухлыг тэмдэглэж байсан чиглэл аль нь вэ?*
 - a. Эвдемонизм
 - b. Гедонизм
 - c. Утилитаризм
 - d. Кинизм
11. *Үүрэг хэмээх ойлголтоор дамжуулан ёс суртахуунт ба ёс суртахуунт бус үйлдлүүдийн хоорондох ялгааг тодорхойлохыг оролдсон философичийг нэрлэ.*
 - a. Демокрит
 - b. Спиноза
 - c. Милль
 - d. Кант
12. *Зөв буруу, сайн мууг ялгаж үзэх объектив зарчим бол "ашиг тусын зарчим" мөн гэж аль чиглэлд үздэг вэ?*
 - a. Натурализм
 - b. Эмотивизм
 - c. Утилитаризм



- d. Теоцентризм
13. Аль нь экологийн ёс зүйн чиг баримжаа вэ?
- Бие биенээ энэрч хайрлах сэтгэл, шударга ёс, хүлээцтэй байх зарчим
 - Амьдралын бүх төрөл, дүрс, байгаль орчныг хайрлах ёс суртахууны үнэлэмж
 - Хүний нэр төрд хүндэтгэлтэй хандах зарчим
 - Сайныг үйлдэж, мууг тэвчиж, хүмүүст хор хөнөөл учруулахгүй байх шаардлага
14. Цэгийн оронд тохирох зөв хариултыг сонгоно уу. Монгол улсын Авлигатай тэмцэх тухай хууль, Мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль нь гол үнэт зүйлээ болгожээ.
- Соёлын ялгааг
 - Шударга ёсны зарчмыг
 - Ёс суртахууны алтан дүрмийн шаардлагыг
 - Ёс заншлыг
15. Ёс зүйн судлах асуудалд аль нь хамаарахгүй вэ?
- аз жаргал
 - амьдралын утга учир
 - чинээлэг амьдрал
 - үүрэг, хариуцлага
16. Субъект холбогдох асуудлаар байр сууриа тодорхой илэрхийлж, тухайн үйлдлийн үр дагаварыг өөрт болон бусдад яаж тусахыг харгалздаг байх чадварыг илэрхийлсэн ойлголт аль нь вэ?
- хариуцлага
 - үүрэг
 - нэр төр
 - шударга ёс
17. Ёс суртахууны алдаа гаргалаа, үүргээ биелүүлсэнгүй гэх мэтээр өөртөө болон бусдад хандсан сэтгэлийн гүн дэх харууслыг илэрхийлсэн ойлголт аль нь вэ?
- Гэмшил
 - Хэрсүү зан
 - Ичих сэтгэл
 - Шударга ёс
18. Аль нь ёс суртахууны нээлттэй асуудалд хамаарахгүй вэ?
- Найдваргүй болсон өвчтөний зовлонг амьдралыг таслан зогсоох нь зүй ёсны хэрэг мөн үү?
 - Үр хөндөлтийг хуульчлан батлах хэрэгтэй юу?
 - Ёс суртахууны хэм хэмжээний үүднээс эгоизмыг буруутгах нь зөв үү?
 - Гадаадад цагаачлах нь зөв үү?
19. Юмсын гол шинж гэж юу вэ?
- Тухайн юмс, үзэгдлийн өнгө, хэлбэр дүрс, хэмжээ гэх мэт шинж тэмдэг
 - Тухайн юмс, үзэгдлийн орших зайлшгүй нөхцөл болж буй шинж тэмдэг
 - Тухайн юмс үзэгдлийн бусдаас ялгарах шинж тэмдэг
 - Тухайн юмс үзэгдлийн шинжүүдийн нэгдэл
20. Аль нь бодомж болж чадах вэ?
- Бид ажлаа хариуцлагатай хийх хэрэгтэй.
 - Бид ажлаа ямагт хариуцлагатай хийдэг.
 - Бид ажлаа хийж дууссан гэдгээ хариуцлагатайгаар мэдэгдье.
 - Бүгд
21. Зөвхөн ойлголтуудаас бүрдсэн мөрийг дугуйлна уу
- Жимс, ой, нуур, өвс
 - Баярлах, ичих, сэтгэл хөдлөх
 - Аялах, зугаалах, баяр
 - Бурхан, шашин, сүсэглэх
22. "Бүх багш спортоор хичээллэдэг". "Бүх багш спортоор хичээллэдэггүй" гэсэн бодомжууд нэгэн зэрэг үнэн байж чадахгүй гэдэг нь аль хуулийн шаардлага вэ?
- Зөрчилгүйн хууль
 - Гуравдахийг үгүйсгэх хууль
 - Хангалттай үндэслэлийн хууль
 - Дээрх бүх хуулийн
23. Ойлголтын багтаамжийг хязгаарлах үйлдлийг зөв хийсэн нь аль вэ?
- Монгол улсын Үндсэн хууль-хууль
 - Хууль- Хөдөлмөрийн хууль
 - Хууль- Монгол улсын Үндсэн хууль- Хөдөлмөрийн хууль
 - Бүгд зөв
24. Дараах ойлголтуудаас агуулгын хувьд аль нь их вэ?
- Нийгмийн шинжлэх ухаан
 - Нийгэм, хүмүүнлэгийн шинжлэх ухаан



36. Цэгийн оронд тохирох зөв хариултыг сонгоно уу. Хувь хүмүүс, бүлэг хамт олны бүтээл, туурвилын үр дүнд бий болсон бэлгэдлийн утга санаа, уран сайхны агуулга, соёлын үнэт зүйлсийг гэдэг.
- Соёлын үйл ажиллагаа
 - Соёлын үйлдвэрлэл
 - Оюуны өмч
 - Соёлын илэрхийлэл
37. Шашин нийгэмд ямар үүрэг гүйцэтгэдэг вэ?
- Хүмүүст үнэлэмжийн чиглүүлэгч утга учрыг авчирдаг. Өөрөөр хэлбэл, хүний амьдралын яагаад?, юуны учир?, ямар утгаар? гэх мэт олон асуултад хариу өгдөг.
 - Хүмүүсийг нэгтгэн, зохицуулах үүрэг гүйцэтгэнэ. Шашны тусламжтайгаар нийгэм бат бөх болж болно.
 - Шашин бол хүнээс далдын дээд мөн чанарт хандах харилцааны хэрэгцээг илэрхийлэгч болохын хувьд хүний үнэт чанарыг сэргээгч, ёс суртахууны эрхэмлэх зүйлсийг тээгч мөн. Хүн далдын хүчтэй харилцаж, тус дэм авдаг гэсэн итгэл үнэмшил нь шүтэн бишрэгчдэд сэтгэл санааны тогтвортой байдлыг бий болгодог.
 - Дээрх бүгд зөв
38. Хүний оюун санаа, авьяас, чадвар, бүтээлч сэтгэлгээний үр дүнд технологи, инноваци, оюуны өмчид суурилсан, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох, бүтээх, үйлдвэрлэх, түгээх үйл явцыг юу гэдэг вэ?
- Соёлын бүтээлч үйлдвэрлэл
 - Соёлын үйлчилгээ
 - Оюуны үйлдвэрлэл
 - Инноваци
39. Соёл, соёлын харилцаа, соёлын даяаршил, соёлын үйлдвэрлэл гэсэн ойлголтуудаас багтаамжаараа аль нь их вэ?
- Соёл
 - Соёлын харилцаа
 - Соёлын өөрчлөлт
 - Соёлын үйлдвэрлэл
40. Соёлын орон зай гэж юу вэ?
- Тухайн улсын хил, хязгаар, талбайг илэрхийлсэн хэмжигдэхүүн
 - Нийгэм-соёлын үнэлэмжүүдийн харилцан нөлөөллөөр бий болж байдаг хамтын мэдрэмж
 - Соёлын нийтлэг хийгээд олон янз байдал, өөрчлөлтийг илэрхийлдэг ойлголт
 - Даяаршлын эринд соёлын бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний солилцоог илэрхийлсэн ойлголт
41. Шинжлэх ухааныг байгалийн ба нийгэм-хүмүүнлэгийн хэмээн ангилах шалгуурт аль нь хамаарахгүй вэ?
- Шинжлэх ухааны үүссэн цаг хугацаа
 - Судлагдахууны онцлог
 - Судлаач-эрдэмтдийн үзэл бодол, байр суурь
 - Судалгааны арга зүй
42. Соёлын үзэгдлүүд тэмдгэн хэлбэрээр оршдог. Тэмдгийн хамгийн түгээмэл хэлбэр нь юу вэ?
- Хэл
 - Ярианы хэл
 - Бичгийн хэл
 - Зохиомол хэл
43. Аль хэм хэмжээнд сахилгын зөрчлийн асуудлыг тусгах вэ?
- Хөдөлмөрийн дотоод журам
 - Хөдөлмөрийн аюулгүй байдлын журам
 - Хамтын гэрээ
 - Тухайн байгууллагын дотоод дүрэм
44. Ямар тохиолдолд ажил олгогч ажилтнаа зургаан сар тутам эрүүл мэндийн үзлэгт хамруулах үүргийг хуулиар хүлээсэн бэ?
- Насанд хүрээгүй хүнийг ажиллуулсан бол
 - Ахмад настныг ажиллуулсан бол
 - Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулсан бол
 - Хүнд нөхцөлд ажиллуулсан бол
45. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн А/430 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан "Ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлыг үнэлэх, дүгнэх журам"-ын зарим заалт зохицуулалт боловсролын хууль зөрчсөн тул хүчингүй болгуулах шаардлагыг хаана хандаж гаргах вэ?
- Сайдын шууд удирдах дээд шатны албан тушаалтан буюу Ерөнхий сайдад
 - Захиргааны хэргийн шүүхэд
 - Үндсэн хуулийн цэцэд



- d. Улсын Их хуралд
46. Иргэн Наран өөрийн найз Баяраас 20 сая төгрөгийг 1 сарын хугацаатай, хүүгүй зээлсэн байна. Наран зээлсэн мөнгөө төлөхгүй 10 сар болжээ. Баяр түүнийг шүүхэд өгөхөөр шийдсэн байна. Аль шүүхэд хандах вэ?
- Нарангийн оршин суугаа газрын Иргэний хэргийн анхан шатны шүүх
 - Өөрийн оршин суугаа газрын иргэний хэргийн анхан шатны шүүх
 - Аймаг, Нийслэлийнхээ захиргааны хэргийн шүүх
 - Хүний эрхийн үндэсний комисс
47. Хэн нь "Аливаа эрх мэдэл хүнийг эвддэг бол хязгааргүй эрх мэдэл хязгааргүй эвддэг" гэх үзэл санааг тунхагласан бэ?
- Жон Локк
 - Ф.Бастиа
 - Р.Нозик
 - Лорд Актон
48. 2024 оны хавар сургуулийн санхүүжилт хоцорсонтой холбоотой засварын ажлыг оройтож эхэлсэн байна. Хичээл эхлэх хугацаа дөхөж байсан тул захирал А багш нарыг засварын ажилд оролцож шавар, шохой цэвэрлэх ажил хийх зайлшгүй шаардлагатай болсон талаар хурлын үеэр хэлжээ. Багш нар тухайн шийдвэрийг биелүүлэх үүрэгтэй эсэх тухайд дараах хариуултуудын аль нь зөв бэ?
- Захирал тухайн шийдвэрийг бичгээр гаргаагүй тул багш нар биелүүлэх үүрэг хүлээхгүй
 - Боловсролын тухай хуульд заасны дагуу шууд удирдах албан тушаалтны шийдвэрийг багш нар биелүүлэх үүрэг хүлээнэ
 - Хүндэтгэн үзэх шалтгаантай, онцгой нөхцөл байдал үүссэн тул багш нар захирлын амаар гаргасан захиргааны актыг биелүүлэх үүрэгтэй
 - Захирлын шийдвэрийн дагуу гүйцэтгэх ажил үүрэг нь Багшийн албан тушаалын тодорхойлолтод тусгагдаагүй тул багш нар биелүүлэх үүрэг хүлээхгүй
49. Иргэн А-г гудамжинд явж байхад үл таних Б хөөрөг худалдаж авахыг санал болгожээ. А хөөргийг үзээд худалдаж авсан. Уг хөөргийг Б нь Д-ээс хулгайлсан бөгөөд энэ талаар А огт мэдээгүй. А-гийн эрх зүйн байдлыг тодорхойлно уу?
- А бол тус эд хөрөнгийн өмчлөгч мөн
 - А бол тус эд хөрөнгийн шууд эзэмшигч мөн
 - А бол тус эд хөрөнгийн шууд бус эзэмшигч мөн
 - А бол тус эд хөрөнгөд хамаарал бүхий этгээд биш
50. Цэгийн оронд тохирох зөв хариултыг сонгоно уу. Иргэн А нь интернэт банкаар гүйлгээ хийхдээ данс андуурч, үл таних Б-гийн дансанд 3 сая төгрөг шилжүүлсэн байна. Б тус мөнгөөр iphone загварын гар утас худалдан авчээ. А-гийн үйлдэл мөн.
- Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг
 - Зөрчлийн хуульд заасан зөрчил
 - Эд хөрөнгийн тухай хуульд заасан зөрчил
 - Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль заасан зөрчил
51. "Саруул монгол" ЕБС нь 12 дугаар ангийн сурагч Б-гийн зургийг сургуулийн сурталчилгааны самбарт байршуулсан байна. Аль тохиолдолд сургуулийн үйлдэл зөв бэ?
- Сурагчаас зөвшөөрөл авсан тохиолдолд
 - Сурагчийн эцэг, эхээс зөвшөөрөл авсан тохиолдолд
 - Сурагч болон эцэг, эхээс зөвшөөрөл авсан тохиолдолд
 - Анги удирдсан багшаас зөвшөөрөл авсан тохиолдолд
52. Иргэн А өөрийн Үндсэн хуульд заасан "эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх" зөрчигдсөн талаар гомдлоо Үндсэн хуулийн цэцэд хандан гаргасан байна. Түүний үйлдэл зөв үү?
- Зөв. Үндсэн эрх зөрчигдсөн талаар маргааныг цэц шийдвэрлэх үүрэгтэй
 - Буруу. Үндсэн хуулийн цэцийн харьяалан шийдвэрлэх маргаанд Хамаарахгүй
53. Доорх үзүүлэлтүүдээс аль нь мэдрэмжтэй эрэлтийн тодорхойлолтод хамаарахгүй вэ?
- Үнийн мэдрэмжийн коэффициент нэгээс их
 - Үнэ есөхөд борлуулалтын орлого өсдөг
 - Үнийн өөрчлөлтөнд хэрэглэгчид харьцангуй мэдрэмжтэй ханддаг
 - Эрэлтийн тоо хэмжээний харьцангуй өөрчлөлт нь үнийн харьцангуй өөрчлөлтийг бодвол их
54. Цэгийн оронд тохирох зөв хариултыг сонгоно уу. Кейнс өрхийн орлого ба хэрэглээ хуримтлал нь хоорондоо шууд хамааралтай учир түүний график нь 45° -ийн налууатай шулуун байна гэж үзсэн. Үүнийг ... гэж нэрлэдэг.
- Өрхүүдийн хэрэглээний функц
 - Кейнсийн загалмай
 - Орлогоос үл хамаарах хэрэглээ
 - Энгелийн хууль
55. Шилжих төлбөрийн тухайд аль нь зөв бэ?



- a. Хариу бүтээгдэхүүн үйлчилгээ нэхэлгүйгээр өрх гэрүүдэд өгч буй төлбөр
b. Зөвхөн хувь хүмүүст өгч буй засгийн газрын төлбөрүүд
c. Үндэсний орлогод тооцогддоггүй орлогын бүрэлдэхүүн хэсэг
d. Дээрх бүх үзүүлэлт зөв
56. Дараах зүйлсийн аль нь "бараг мөнгө" -нд тооцогдохгүй вэ?
a. Чекийн бус хадгаламж
b. Богино хугацаат хадгаламж
c. Кредит картууд
d. Их хэмжээний хугацаатай хадгаламжууд
57. Цэгийн оронд тохирох зөв хариултыг сонгоно уу. Орлого өсөхийн хэрээр хэрэглээний бүтцэд өөрчлөлт гарах боловч анхдагч хэрэглээний зардлаас хоёрдогч хэрэглээний зардал ямагт өсч байдаг гэдгийг анх
. нээсэн.
a. Кейнс
b. Ж.Б. Сей
c. Э. Энгель
d. Д.Рикардо
58. Аль нь 2022 оны Монгол улсын ДНБ-д тооцогдохгүй вэ?
a. 2022 онд Эрдэнэт хотод байрладаг гадаадын компанийн угсарч, худалдаалсан багаж хэрэгсэл
b. 2020 онд эхэлж 2022 онд дууссан барилга угсралтын ажил
c. 2022 онд улсын захиалгаар үйлдвэрлэсэн барилга
d. 2022 онд монгол ажилчны Солонгос улсад үйлдвэрлэсэн цамц
59. "А" бүтээгдэхүүний зах зээл дээр 25 хэрэглэгч байна. Хэрэглэгч тус бүрийн эрэлт нь $Q_d = 20 - P$ функцээр тодорхойлогддог. Зах зээлийн нийлүүлэлт нь $Q_s = 50P - 250$ функцээр өгөгдсөн. Хэрэглэгч бүрт тэнцвэртэй байх "А" бүтээгдэхүүний тэнцвэрт хэмжээг тодорхойлно уу.
a. 5 нэгж бүтээгдэхүүн
b. 10 нэгж бүтээгдэхүүн
c. 15 нэгж бүтээгдэхүүн
d. 20 нэгж бүтээгдэхүүн
60. Цэгийн оронд тохирох зөв хариултыг сонгоно уу. Хэрэв үнийн түвшин өсч үйлдвэрлэл унаж байгаа бол энэ нь ... мөн
a. Нийт эрэлтийн муруйн баруун тийш хийх шилжилт
b. Нийт эрэлтийн муруйн зүүн тийш хийх шилжилт
c. Нийт нийлүүлэлтийн муруйн баруун тийш хийх шилжилт
d. Нийт нийлүүлэлтийн муруйн зүүн тийш хийх шилжилт
61. Дараах судалгааны аль нь нийгмийн давхраажилтыг объектив байдлаар хэмжин судлах арга зүйд багтах вэ?
a. Та ямар давхраанд хамаарах вэ гэж хувь хүнээс асуух
b. Ажил мэргэжлийн нэр хүндийн зэрэглэлийг тухайн хүний боловсрол, орлогын хэмжээгээр тодорхойлох
c. Ямар, ямар ажил эрхэлж буй хүмүүс дунд давхраанд багтах вэ гэж асуух
d. Танай хотын дээд давхраанд ямар шинж бүхий хүмүүс багтах вэ гэж асуух
62. Нийгэм дэх хэм хэмжээ хүмүүсийн үйлдлийн удирдлага, чиг баримжаа болж чадахгүй нөхцөл байдлыг Э.Дюркгейм ямар ойлголтоор илэрхийлсэн бэ?
a. Нийгмийн гажуудал
b. Нийгмийн аноми байдал
c. Нийгмийн хямрал
d. Нийгмийн хэм хэмжээгүйдэл
63. Тодорхой шинжээр ялгаагүй ч стандарт, хэм хэмжээ нь нийгмийн тодорхой нийтлэгийн гишүүнийг ялгаварлах үр дагавар бүхий байдал нь ямар төрлийн ялгаварлан гадуурхалтад хамаарах вэ?
a. Шууд ялгаварлан гадуурхалт
b. Ил ялгаварлан гадуурхалт
c. Шууд бус ялгаварлан гадуурхалт
d. Институтчлэгдсэн ялгаварлан гадуурхалт
64. Ядуурал, өвчин зовлон, тэгш бус байдал зэрэг шударга бус үзэгдлийг даван туулахад шашин тусалдаг гэж социологийн аль онол үздэг вэ?
a. Бүтэц чиг үүргийн онол
b. Марксизм
c. Зөрчилдөөний онол
d. Бэлгэдлийн харилцан үйлдлийн онол
65. Сургууль нь капиталист үйлдвэрлэлийн хэрэгцээнд чиглэж, хувийн өмчийг хамгаалах, ашгийг эрмэлзэх байдлыг нийгмийн дээд ашиг сонирхол гэж үздэг хүн амын бүлгийн итгэл үнэмшлийг дамжуулах, зөвтгөх хэрэгсэл болдог гэж социологийн ямар онол үздэг вэ?



- a. Бүтэц чиг үүргийн онол
b. Марксизм
c. Зөрчилдөөний онол
d. Бэлгэдлийн харилцан үйлдлийн онол
66. Аль нь зөв бэ?
a. Эрүүл мэнд хэмээх ойлголт дэлхий дахинаа ижил утгатайгаар хэрэглэгддэг
b. Эрүүл мэнд бол өвдөх, зовиурлахтай холбоотой зөвхөн бие организмд хамаарах ойлголт
c. Эрүүл мэнд бол нийгмийн амьдралын нөхцөл байдал гэхээс хувь хүнээс өөрөөс нь хамаардаг
d. Эрүүл мэнд хэмээх ойлголт нь түүхэн тодорхой үе хийгээд нийгмүүдэд харилцан адилгүй утгатай
67. Аль нь Ж.Г.Мидийн "Би намайг" хэмээх ойлголтын утгыг зөв илэрхийлж байна вэ?
a. Бусад хүний үйлдэл ямар утгатай болохыг ойлгохуй.
b. Харилцагч субъект намайг хэрхэн төсөөлж, миний хариу үйлдлийг хэрхэн тооцоолж байгааг ойлгохуй
c. Бусдыг хүлээн авах, хариу үйлдэл үзүүлэх хувийн чадвар
d. Эргэн тойрны ертөнцийн утгыг илэрхийлэх бэлгэ тэмдгийг бүтээх, ашиглах чадвар.
68. Ахмад настны нийгэмшилтийн онцлог юу вэ?
a. Бие махбодь, танин мэдэхүй, хандлага нь бага хөгждөг
b. Байр суурь, үүргийн хүлээлт нь тодорхойгүй тул бага өөрчлөгддөг.
c. Зайлшгүй болон гэнэт тохиолдох хямралыг даван туулах байдлаар нийгэмшдэг.
d. Хүрээлэн буй бүхэнд идэвхтэй хариу үзүүлэх замаар нийгэмшдэг
69. Монгол Улсын үндсэн хуулийн тайлбарыг хэн хийдэг вэ?
a. Улсын Их Хурал
b. Засгийн газар
c. Ерөнхийлэгч
d. Үндсэн хуулийн цэц
70. Цэргийн эрх мэдлээс улбаатай эдийн засгийн байр суурьтай холбоо бүхий, төрөөс тогтоосон хэргэм зэрэгт үндэслэсэн төрийн үйл ажиллагаанд оролцох эрхээрээ ялгаатай, эрх зүйн хувьд баталгаажсан, хаалттай давхраажилтын хэв маяг аль нь вэ?
a. Боолчлолын
b. Язгуурын
c. Кастын
d. Ангийн
71. Ардчиллын талаарх Сонгодог элитийн онолын төлөөлөгчдийг тэмдэглэсэн мөрийг дугуйлна уу.
a. М.Вебер, Ларри Даймонд
b. Г.Моска, В.Парето, И.Шумпетер
c. Ф. Фукуяама, С.Хантингтон
d. Р.Даль, Ж.Дью
72. Хантингтон ардчиллын гурван давалгааг тодорхойлсон байдаг. Тэрээр 2 дугаар давалгааны үеэр аль улсад ардчиллын үйл явц эрчимтэй өрнөсөн гэж үзсэн бэ?
a. Франц
b. АНУ
c. Энэтхэг
d. Польш
73. Аль нь "Иргэний нийгэм"-д үл багтах вэ?
a. Төрийн бус байгууллагууд
b. Мэргэжлийн холбоод
c. Үйлдвэрчний эвлэл
d. Корпораци
74. Цэгийн оронд тохирох зөв хариултыг сонгоно уу. М.Дюверже улс төрийн намыг гэж ангилсан.
a. Элитийн ба массын
b. Кадрын ба массын
c. Катч-ол ба сонгогчдын
d. Бүгд буруу
75. Цэгийн оронд тохирох зөв хариултыг сонгоно уу. БНМАУ-ын 1960 оны Үндсэн хуульд эрхийг хуульчилсан.
a. Иргэд нь шууд буюу төлөөлсөн байгууллагаараа уламжлан улс ба нийгмийг удирдах хэрэгт чөлөөтэй оролцох эрх
b. Нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам байгуулах, нэгдэх эрх
c. Хувийн өмчтэй байх эрх
d. Бүгд зөв
76. Дараах эрдэмтдээс хэн нь ардчиллын плюралист онолын төлөөлөгч вэ?
a. Д.Истон
b. Р.Даль
c. Ж.Локк

- d. Бүгд зөв
77. Дэлхийн II дайны дараа олон улсын харилцаанд ямар систем тогтсон бэ?
- Нэг туйлт
 - Хоёр туйлт
 - Гурван туйлт
 - Олон туйлт
78. Аль нь олон улсын харилцаанд үзүүлэх нөлөөгөө хадгалахыг эрмэлзсэн шинжтэй гадаад бодлого вэ?
- Статус кво бодлого
 - Хүрээгээ тэлэх бодлого
 - Нэр алдрын бодлого
 - Жижиг гүрний бодлого
79. Хөгжиж буй орнуудын онцлог юу вэ?
- Технологи, шинжлэх ухаан, оюуны багтаамжтай салбарт шилжсэн тул үйлдвэрлэлийн үр ашгийн хувьд өндөр түвшинд хүрсэн орнууд
 - Хүний оюуны чадавхад түшиглэн гаднаас хөрөнгө, техник технологи авч өөрийн онцлогт тохируулан чадамгай ашиглаж, хөгжлийн тодорхой түвшинд хүрсэн улс орнууд
 - Өмчийн олон хэвшил бүхий эдийн засагтай, гадаадын хөрөнгө оруулалт, санхүүгийн байдлаас ихээхэн хамааралтай, колонийн системд багтаж байсан орнууд
 - Хуучин социалист системийн бүрэлдэхүүнд багтаж байсан бөгөөд нийгэм, эдийн засгийн гүн гүнзгий өргөн хүрээг хамарсан өөрчлөлт явагдаж, зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэн улс орнууд
80. Олон улсын харилцаанд оролцож буй улс орнуудыг хэт их гүрэн, их гүрэн, дундаж гүрэн, жижиг улс хэмээн ангилдаг. Их гүрэн гэсэн ангилалд тохирох тодорхойлолтыг олно уу.
- Тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдлаа бие дааж хамгаалах хангалттай арга хэрэгсэл, нөөцтэй орон
 - Дэлхийн хөгжилд чухал нөлөө үзүүлж чадах боловч олон улсын харилцаанд ноёрхож чадахгүй орон
 - Өөрийн хөрш орнууддаа нөлөөлж чадах бөгөөд энэ нь тэднийг жижиг улсаас ялгана.
 - Дэлхий дахин, олон улсын харилцаанд бүхэлд нь нөлөө үзүүлэх боломжтой орон



Сорилын хариулт бичих. Багш



1.	2.	3.	4.	5.	6.	7.	8.	9.	10.
11.	12.	13.	14.	15.	16.	17.	18.	19.	20.
21.	22.	23.	24.	25.	26.	27.	28.	29.	30.
31.	32.	33.	34.	35.	36.	37.	38.	39.	40.
41.	42.	43.	44.	45.	46.	47.	48.	49.	50.
51.	52.	53.	54.	55.	56.	57.	58.	59.	60.
61.	62.	63.	64.	65.	66.	67.	68.	69.	70.
71.	72.	73.	74.	75.	76.	77.	78.	79.	80.

Сорилын хариулт бичих. Багш



1.	2.	3.	4.	5.	6.	7.	8.	9.	10.
11.	12.	13.	14.	15.	16.	17.	18.	19.	20.
21.	22.	23.	24.	25.	26.	27.	28.	29.	30.
31.	32.	33.	34.	35.	36.	37.	38.	39.	40.
41.	42.	43.	44.	45.	46.	47.	48.	49.	50.
51.	52.	53.	54.	55.	56.	57.	58.	59.	60.
61.	62.	63.	64.	65.	66.	67.	68.	69.	70.
71.	72.	73.	74.	75.	76.	77.	78.	79.	80.